## ШААРДЛАГА 2 МАЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДЭД МАЛ ЭМНЭЛГИЙН ГЭРЧИЛГЭЭ АВАХ

1. Гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс тодорхойлолт авна.
2. Сумын МЭ-ийн улсын байцаагч баталгаажуулж МЭЕГ-ын мэдээллийн нэгдсэн санд илгээнэ.

## ШААРДЛАГА 3 ТАТВАРЫН ЦАХИМ ТӨЛБӨРИЙН БАРИМТЫН СИСТЕМД БҮРТГҮҮЛЭХ



### ЦАХИМ ТӨЛБӨРИЙН БАРИМТЫН СИСТЕМ /EBARIMT/-Д КОМПЬЮТЕРООС ХЭРХЭН БҮРТГҮҮЛЭХ ВЭ?

### АЛХАМ 1

Иргэн та http://ebarimt.mn/ **"ХУВЬ ХҮН"** нэвтрэх хэсгийн доор байрлах шинээр **Бүртгүүлэх** хэсэгт өөрийн Регистрийн дугаар, Утасны дугаар болон Цахим шуудангаа оруулан **Хүсэлт илгээ**х товчийг дарна.






Амжилттай бүртгэгдлээ. Таны нууц үг и-мэйл хаягаар очих тул и-мэйл хаягаа шалгаарай.

**Хүсэлт илгээх** товч дарсны дараа таны нууц үг email хаягт очих тул та **өөрийн email хаяг** руу нэвтэрч нууц үгийг авна.

## АЛХАМ 2

Иргэн таны бүртгүүлсэн цахим шуудан /email/-д ирсэн хэрэглэгчийн **8 оронтой код болон нууц үгээр** http://ebarimt.mn руу хандалт хийж нэвтэрч орно.



## АЛХАМ 3

Ebarimt системд нэвтэрч орсны дараа **"Данс тохируулах"** цэсэн дээр дарж өөрийн мэдээллээ оруулан **"Хадгалах"** товчийг дарна.









## ЦАХИМ ТӨЛБӨРИЙН БАРИМТЫН СИСТЕМ /EBARIMT/-Д ГАР УТАСНААС ХЭРХЭН БҮРТГҮҮЛЭХ ВЭ?

## АЛХАМ 1

Иргэн та өөрийн ухаалаг утсан дээр ebarimt аппликейшн суулгах шаардлагатай. Үүний тулд таны утас **Андройд** үйлдлийн системтэй бол гар утасны **PLAY STORY**-оос ebarimt аппликейшн татаж суулгана. Хэрвээ **IOS** үйлдлийн системтэй бол гар утасны **APP STORY**-оос ebarimt аппликейшн татаж суулгана.

App Store

Нэвтэрч орсны дараа **ebarimt** хайлт хийж **Download** хийж гар утсандаа аппликейшнийг суулгана.

Play Store

## АЛХАМ 2

Гар утасны ebarimt аппликейшн рүү нэвтэрч орсны дараа **БҮРТГҮҮЛЭХ** товчийг дарна. Өөрийн цахим шуудан, овог нэр, регистрийн дугаар болон утасны дугаарыг оруулан **ИЛГЭЭХ** товчийг дарна.



## АЛХАМ 3

Иргэн таны бүртгүүлсэн цахим шуудан /email/-д ирсэн хэрэглэгчийн **8 оронтой код** болон **нууц үгээр** ebarimt аппликейшн рүү хандалт хийж нэвтэрч орно.




## АЛХАМ 4




ebarimt системд нэвтэрч орсны дараа **“Бусад”** цэсийн **Миний бүртгэл** дэд цэсэд хандаж, гарч ирсэн талбарын мэдээллийг бөглөн **“Хадгалах”** товчийг дарна.




